

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас 2018 оны 6 сарын дугаар

Тэргүүн Мэдээ

Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөрийн буцалтгүй тусламжийн гэрээ байгуулав.



6-р сарын 25-нд Монгол Улсын Сангийн яаманд “Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөрийн” буцалтгүй тусламжийн гэрээнд гарын үсэг зурах ёслол болов. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Монголын ирээдүйг авч явах төрийн залуу албан хаагчдад Японы их дээд сургуулийн магистрын сургалтанд суралцах тэтгэлгийг олгох бөгөөд гэрээнд гарын үсэг зурснаар энэ жил 22 оюутан суралцах боломжтой болох юм.

Энэ хөтөлбөр хэрэгжсэнээр Японд суралцаж төгссөн боловсон хүчин тухайн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд бодитой хувь нэмэр оруулахын зэрэгцээ хоёр улсын харилцан ойлголцол, найрамдалт харилцааг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулна гэдэгт найдаж байна.

Улс төр, эдийн засгийн чиг хандлага

Монгол, Хятад, Оросын дээд хэмжээний 4 дүгээр уулзалт болов.

6 сарын 9-ний өдөр Шаньдун мужийн Чиндао хотод эхэлсэн ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтад оролцохоор БНХАУ-д хүрэлцэн ирсэн ШХАБ-ын ажиглагчийн статустай Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, БНХАУ-ын дарга Ши Жинпин, ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путин нарын дөрөв дэх уулзалт болов. Энэхүү дээд хэмжээний уулзалтаар талууд 3 улсыг холбосон эдийн засгийн коридор байгуулахын ач холбогдолыг тэмдэглэж, ачаа тээврийн салбарт хамтын ажиллагаагаа бэхжүүлэх эрмэлзлээ нотлов.

Төслийн хэрэгжилт

Комотек компанийн тортог шүүгчийг (DPF) Улаанбаатар хотын нийтийн тээврийн автобусанд суурилуулж эхлэв.



Улаанбаатар хотын агаарын бохирдлын нэг эх үүсвэр нь автомашины хаягдал хий бөгөөд түүний 60 хувь нь нийтийн тээврийн автобуснаас гаралтай гэж үздэг. ЖДҮ-ийг гадаадын зах зээлд гарахад нь дэмжлэг үзүүлэх ЖАЙКА-н хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын нийтийн тээврийн автобусны дизель хөдөлгүүрт DPF (Diesel Particulate Filter) тортог шүүгчийг суурилуулж хөдөлгүүрээс ялгарах тортогжилтыг бууруулах туршилтын төсөл”-өөр Комотек компанийн тортог шүүгчийг суурилуулж хорт хийн ялгарлыг бууруулах зорилготой. Өмнө нь хаягдал хийн ялгарлын хэмжилт, тоног төхөөрөмжийн бэлтгэл гэх мэт ажлууд хийгдсэн бөгөөд 6 сард нийслэлийн нийтийн тээврийн автобуснуудад эдгээр тортог шүүгч төхөөрөмжүүдийг тавьж эхлэв. Цаашид ашиглалтын явцад энэхүү төхөөрөмж нь бодит үр дүнгээ өгнө гэж найдаж байна.

Үе тэнгийн зөвлөх сургагч багшийн 3 өдрийн сургалт болов.



6 сарын 23-25-ны өдрүүдэд өвсний үндэс ТХА-ны “Өсвөр үеийнхнийг эрүүл аж төрөх дадалд суралцуулах тогтвортой тогтолцоо байгуулах төсөл”-ийн (Япон талын хэрэгжүүлэгч байгууллага нь Жичигийн анагаах ухааны их сургууль) хүрээнд Үе тэнгийн зөвлөх үйл ажиллагааны (Peer counselor training course) сургагч багш бэлтгэх сургалт боллоо. Төсөл нь тулгамдаж буй аливаа асуудлын талаар харилцан сонсон, дэмжин, хамтдаа гарцыг хайн зөвлөх аргыг ашиглан, өсвөр үеийнхэн өөрсдөө эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх механизмыг бий болгож байна. Энэ удаагийн аургалтанд Улаанбаатар хотын загвар сургуулийн багш, сувилагч зэрэг 13 хүн хамрагдсан ба цаашид Үе тэнгийн зөвлөхийг бэлтгэхэд үүрэг гүйцэтгэх юм.

Адууны нийлүүлгийн өвчний түргэвчилсэн оношлуурыг нэвтрүүлэх бэлтгэл явагдаж байна.



SATREPS “Монгол оронд тохиолддог малын цусны шимэгч, эгэл биетнээр үүсдэг өвчний тархалтын судалгаа, оношилгооны оновчтой арга боловсруулах нь” төслийн хүрээнд боловсруулсан адууны нийлүүлгийн өвчний түргэвчилсэн оношлуурыг борлуулах албан ёсны зөвшөөрөл олгогдон Монгол улсын засгийн газар 1400 ширхэгийг худалдан авч энэ жил ашиглахаар боллоо. Эдгээр оношлуурууд нь Монгол улсад борлуулагдаж буй импортын бүтээгдхүүнээс хямд тул цаашид өргөнөөр ашиглагдана гэдэгт найдаж байна. 5 сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан төслийн хамтарсан зохицуулах хорооны хурал дээр энэхүү үр дүнг өндрөөр үнэлсэний сацуу малын шимэгч, эгэл биетнээр үүсдэг бүх төрлийн өвчний гарын авлага үр дүнтэй ашиглагдаж буйг онцлон тэмдэглэв.

“Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн Хамтарсан зохицуулах хорооны 2 дугаар хурал хуралдав.



6 дугаар сарын 15-ны өдөр “Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх Техникийн хамтын ажиллагааны төсөл”-ийн Хамтарсан зохицуулах хорооны 2 дугаар хурал хуралдаж, барилгын аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийн талаарх судалгаа болон барилгын талбай дахь эрсдлийн үнэлгээний хуудас боловсруулах ажил ерөнхийдөө төлөвлөгөөний дагуу сайн явагдаж байгааг тэмдэглэв. Цаашид “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр”-ийн барилгын салбарын дэд хөтөлбөрийг боловсруулах, Япон дахь сургалтыг зохион байгуулах зэргээр 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хоёр тал хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллана.

Сайн дурын үйл ажиллагаа

Сайн дурын гишүүний үйл ажиллагааны танилцуулга

Хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд чиглэсэн уран зураг, дүрслэх урлагийн хичээл



Монголд “Хүүхдийн бүтээлч сэтгэхүй”-г хөгжүүлэхэд чиглэсэн уран зураг, дүрслэх урлагийн хичээл нэвтэрч эхэлсэн хэдий ч ихэнхдээ сурах бичиг дээр байгаа бүтээлийг дуурайж хийдэг тул өөрөө сэтгэн бодож, бие даан бүтээл хийх нь бэрхшээлтэй гэж ойгодог хүүхэд олон байдаг.

Сайн дурын гишүүн Ямада Ацуши (2017 оны 1-р ээлж/ Бага ангийн багш) нь хүүхдүүдийн энэ ойлголтыг өөрчлөхийн тулд хүүхэд тус бүрийн онцлогийг чухалчлан үзэж, янз бүрийн сэдэв болон хэрэглэгдэхүүнтэй харьцаж сурах зорилготой хичээл сургалтыг явуулж, хүүхэд өөрөө бие даан бодож сэтгэн, урам зоригтойгоор бүтээл хийх чадвартай болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна.

Сайн дурын бусад үйл ажиллагааны мэдээ

- Дэлхий даяарх ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн тэмдэглэл: Сайн дурын гишүүн Оно Юки (2016 он 2-р ээлж/ Нийгмийн ажилтан)
- Дэлхийн халуун цэг: Сайн дурын гишүүн Гогами Масаюки (2016 оны 1-р ээлж/ Хөдөлгөөн засалч) “Монголд хөдөлгөөн засалчаар”



ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбоо

2017 оны “Шилдэг туршлага нэвтрүүлэгч”-дийг танилцуулж байна (3)



ҮАБЗ-ийн Ажлын албаны Ахлах референт Ё.Жаргалсайхан нь Япон улсад зохион байгуулсан “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, гамшгийн хохирлыг бууруулах Япон Монголын хамтарсан семинар” (2012 он) болон “Гамшгаас хамгаалах салбарын танилцах аялал”-д (2016 он) оролцож байсан. Тэрээр эх орондоо буцаж ирээд Япон улсад сурсан мэдсэнээ ашиглан сургалт семинарууд зохион байгуулж, барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийн судалгаа хийж, заавар зөвлөгөө өгснөөс гадна сургалт төгсөгчдийн холбооны санхүүжилтээр “Японы гамшгийн эрсдлийн удирдлагын туршлага, Монголд нэвтрүүлэх боломж” сэдэвт семинар зохион байгуулсан. Түүний энэхүү хүчин чармайлтыг өндрөөр үнэлж, ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбооны 2015, 2017 оны “Шилдэг туршлага нэвтрүүлэгч”-ээр шалгаруулсан байна.